

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН /ӨССӨН ДҮНГЭЭР/

2019 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хот

“Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем”-ийг ашиглан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлүүлэх, эргэн мэдээлэх үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 2019 оны 06 дугаар сарын 25-ний өдрийг дуустал нийт 591 өргөдөл, гомдол ирсэн байна. Нийт 591 өргөдлөөс шийдвэрлэсэн 560 буюу 95,0%, шийдвэрлэх шатандаа 31 буюу 0,5%-тай шийдвэрлэгдсэн байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 21 цаг 15 минут буюу индексийн үнэлгээ 0,83 “В” үнэлгээгээр дүгнэгдсэн.

2019 оны 2 дугаар улирлын иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийн хандалтын байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд СӨХ болон газрын асуудлаар хамгийн их хандсан байх тул дараах ажлыг зохион байгуулсан.

1. Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын хамтын ажиллагааг чанаржуулах, дэмжих, холбогдох хууль тогтоомжийг сурталчилах, иргэд оршин суугчдын амьдрах орчныг сайжруулах үүднээс дундын өмчлөлийн эд хөрөнгийг бүртгэлжүүлэх, эзэнжүүлэх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэхэд зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Нэгдсэн зөвлөгөөн-5” арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.
2. Баянгол дүүргийн Сууц өмчлөгчдийн холбооны Нэгдсэн зөвлөлтэй хамтран Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, дэмжих, захирлуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гүйцэтгэх захирлуудын ажлын гарын авлагын мэдээллийг хууль, тогтоомжийн хүрээнд боловсруулан гаргаж 7 хоног бүр тулгамдсан асуудалтай 1 СӨХ-г сонгон авч газар дээр нь ажиллаж асуудлуудыг шийдвэрлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.
3. Гэмт хэргийн гаралт нэмэгдэж хулгай, дээрэмд хүүхэд, эмэгтэйчүүд ихээр өртөж байгаатай холбогдуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран техникийн үзүүлэлт, шаардлага хангахуйц камерын судалгааны ажлыг хийх, суурилуулах, ажиллахгүй болсон камерын эвдрэл гэмтлийг засварлах, сайжруулах, арчлалт хамгаалалт хийж ажиллахыг дүүргийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр албан даалгавар гаргаж сууц өмчлөгчдийн холбоодод хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

4. Иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сууц өмчлөгчдийн холбоодын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах, хууль, хяналтын олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор ухуулга сурталчилгаа хийх ажлыг сууц өмчлөгчдийн холбооны Дээд зөвлөл, Нэгдсэн зөвлөлтэй хамтран сард нэг удаа удирдлагын хурал зохион байгуулж ажиллаж байна.
5. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, автозамын орц гарцыг хааж барьсан хашаа, барилга байгууламж болон түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэх гомдлын дагуу 26 зөрчлийг арилгасан.
6. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй чанартай хүргэх, мэдээ, мэдээллээр хангах, өргөдөл гомдол, санал хүсэлтийг түргэн шуурхай хүлээн авах зохилгоор 1800-1222 тусгай дугаарыг нэвтрүүлэн ажилуулж иргэдэд эрх зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх, эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжтой холбоотой асуудлаар, мөн нийгмийн халамжийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулахын тулд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



1. Нийслэлийн Засаг даргын А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хороодын хэсгийн ахлагч нарт “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем-ERP” програм ашиглалтын танилцуулга, сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 46 хэсгийн ахлагч хамрагдаж иргэдийн өргөдөл, гомдол санал, хүсэлтийг хороон дээр хүлээн авч цахим програмд бүртгэн шийдвэрлэх, удирдлагад шилжүүлэх, иргэдэд цаг алдалгүй хариу өгөх, үр дүнг тооцох, нийслэлээс гаргах бодлого шийдвэрт иргэдийн санал бодлыг тусгах боломжтой болсон.
2. Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг баримтлан

өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бодитой шийдвэрлэж ажиллахыг харьяа хэлтэс, албадад үүрэг болгон шийдвэрлэлтэд хяналт тавин өдөр тутам арга зүйн зөвлөгөө өгч байна.

3. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавин, иргэдээс ирүүлж байгаа өргөдөлд дүн шинжилгээ хийж сар, улирал бүр www.bgd.mn цахим хуудсанд байршуулсан.
4. 2019 оны 06 дугаар сарын 28-ний өдөр Баянгол дүүргийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар өргөдөл гомдлын хоёрдугаар улирлын шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж цаашид анхаарч ажиллах ажлын асуудлаар заавар зөвлөмж өгч ажиллалаа.
5. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй, хугацаа хэтрүүлэн ажилласан төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцон арга хэмжээ авч ажиллахыг харьяа хэлтэс албад, хороодод үүрэг даалгавар хүргүүлж, сануулах арга хэмжээ авч ажилласан.
6. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд түргэн шуурхай, чанартай үйлчлэх зорилгоор өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үнэлээг албан хаагч тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд тусган хяналт тавин ажиллаж байна.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.МӨНХЗУЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ГЭРЭЛЭЭ